


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын болон Ховд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөр бүтээлийн өндөр амжилт гаргасан өмчийн бүх төрлийн болон төрийн бус иргэний нийгмийн байгууллагын ажиллагсад, иргэдийг шагнаж урамшуулахаар нэр дэвшүүлэх, уламжлах, хүлээн авч шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Аймаг нь дараах төрлийн шагналтай байна.

1.2.1. Аймгийн дээд шагнал “Галдан бошигт хаан”-ы нэрэмжит шагнал

1.2.2. Аймгийн “Хүндэт иргэн”

1.2.3. Аймгийн “Зуун эрхэм”

1.2.4. Аймгийн “Хүндэт тэмдэг”

1.2.5. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулах

1.2.6. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Ховдын төлөө” медаль

1.2.7. Аймгийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөл

1.2.8. Аймгийн Засаг даргын Жуух бичиг

1.2.9. Аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөл

1.2.10. Аймгийн Есөн алдартан

1.2.11. Аймгийн Тэргүүний сум, баг, байгууллага

1.3. Аймгийн шагналыг жил бүрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны тогтоолоор баталсан “Аймгийн нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тохиолдуулан олгоно.

Хоёр. Аймгийн шагналд нэр дэвшүүлэх, уламжлах:

2.1. Шагналд нэр дэвшигчийн тодорхойлолтод эрхэлсэн ажилдаа гаргасан амжилт, бүтээл, дэвшилтэт шинэ санал, санаачилга болон түүнийг хэрэгжүүлснээр хүрсэн үр дүнг тодорхойлон баримтаар дурдаж, тухайн амжилтанд тохирох шагналын нэр, төрлийг заасан байна.

2.2. Тухайн байгууллагын тодорхойлолт, холбогдох материалыг харьяалах сумын Засаг дарга хянан судалж үзээд аймгийн Засаг даргад саналын хамт уламжилна.

2.3. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний болон үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийн байгууллагуудын ажилтнуудыг тухайн байгууллагын дарга нь тодорхойлж, аймгийн Засаг даргад өргөн мэдүүлнэ.

2.4. Шагналын тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст ирүүлснээс хойш ажлын 5 хоногт багтаан судалж, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.

2.5. Тус журмын 1.2 дахь заалтын 1.2.1, 1.2.2, 1.2.3, 1.2.4, 1.2.5-д заасан шагналуудын тодорхойлолтыг аймгийн Засаг даргын саналын хамт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад өргөн барьснаар Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

2.6. Журмын 1.2.1-1.2.6-д заасан шагналыг иргэнд 1 удаа олгоно.

2.7. Хугацаа хожимдсон болон тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг дутуу бүрдүүлсэн бол буцаах ба шагнуулахаар хэлэлцүүлэхгүй.

2.8. Аймгийн шагналаар шагнуулахаар өргөн мэдүүлэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

2.8.1 Ажил байдлын тодорхойлолт

2.8.2 Хамт олны хурлаар хэлэлцсэн тухай тэмдэглэл, шийдвэр

2.8.3 Эрхэлсэн ажлын сүүлийн 3-5 жилийн үзүүлэлт

2.8.4. Шагналд нэр дэвшигчийн анкет (хавсралтаар)

2.8.5. Тухайн байгууллагын дарга болон харьяалах сумын Засаг даргын дэмжиж уламжилсан албан бичиг зэрэг байна.

Гурав: Шагнал олгоход баримтлах шалгуур үзүүлэлт, бүртгэлийн сан:

3.1. Аймгийн шагналыг дараах шалгуур үзүүлэлтүүдийг баримтлан үнэлж тус журмын дагуу шийдвэрлэнэ.

3.1.1. Аймгийн дээд шагнал “Галдан бошигт хаан”-ы нэрэмжит шагнал:

Монгол улсын баруун бүс нутаг болон Ховд аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, хүн амын хөгжилд онцгой хувь нэмэр оруулж, гарамгай амжилт, дэвшилтэт шинэ бүтээл гаргасан нийгэм, эдийн

засгийн салбараас жилд 2 хүртэлх хүнийг шагнана. “Галдан бошигт хааны нэрэмжит шагнал”-ыг 1000000 төгрөг /нэг сая/, дурсгалын зүйл (таван зуун мянган төгрөгт багтаан Галдан хааны хөшөөний жижигрүүлсэн хувилбарыг бүтээж, хадгалуулна) дагалдана.

3.1.2. Аймгийн “Хүндэт иргэн”:

Төр, өмчийн бүхийл хэвшлийн байгууллагад 30-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, аймгийг хөгжүүлэх, бүтээн байгуулах, дэд бүтцийг бүрдүүлэх, хүн амын нийгмийн асуудлыг дээшлүүлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, өсвөр үеийг хүмүүжүүлэх, бүх төрлийн үйлдвэрлэл үйлчилгээний хүрээг өргөтгөж, үр ашгийг дээшлүүлэх, төр захиргааны ажлыг боловсронгуй болгон төгөлдөржүүлэх, шинжлэх ухаан технологийн ололт, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, нийгмийн дэг журмыг сахиулах, хууль ёсыг биелүүлэх зэрэг аймгийн өмнө тулгамдсан зорилтыг амжилттай шийдвэрлэхэд онцгой хувь нэмэр оруулж үр бүтээл гаргасан Монгол улсын иргэн, аймаг орон нутагт ажиллаж амьдарч буй хөдөлмөрийн баатар цолтон, Ховд аймгийн төр захиргааны байгууллагыг удирдан тодорхой үр дүнд хүргэсэн хүмүүсийг шагнана.

Аймгийн “Хүндэт иргэн” шагналыг гэрэгэ дагалдуулж, 500000 төгрөг \таван зуун мянга\-ийн урамшуулал үзүүлнэ.

3.1.3. Аймгийн “Зуун эрхэм”:

Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд олон жилийн хөдөлмөр бүтээлээ зориулан идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан иргэнийг Ховд аймгийн “Зуун эрхэм”-ийн нэгээр шалгаруулж, “Зуун эрхэм” тэмдэг, батламж, 100000 төгрөг /Нэг зуун мянга/-өөр шагнана. Жилдээ 5 хүртэлх иргэнийг шалгаруулж, нийт 100 иргэн шагнагдана.

3.1.4. Аймгийн “Хүндэт тэмдэг”:

Аймгийн нийгэм, эдийн засаг, өмчийн бүх хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, сум, багийг хөгжүүлэх, өөрийн эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гаргаж, бусдыг үлгэрлэн хошуучилж ажилласан тэргүүний хүмүүсийг шалгаруулан шагнана.

Ховд аймгийн “Хүндэт тэмдэг”-ийг 50000 төгрөг \тавин мянга\-ийн шагнал дагалдах бөгөөд мөнгөн шагналыг шагналд тодорхойлсон байгууллагаас олгоно.

3.1.5. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулах:

Аймаг, орон нутагт ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан иргэд, улс, олон улсын чанартай соёл, спортын арга хэмжээнд амжилт гаргасан болон олон үндэстэн ястны өв соёлыг хадгалан хамгаалж түгээн дэлгэрүүлсэн хүмүүс,

төрийн дээд шагнал хүртсэн /төрийн соёрхолт, ардын цолтон, хөдөлмөрийн баатар, Монголын шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн (академич) /Ховд аймгийн уугуул иргэд болон аймаг орон нутгийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан /1 жилд 5 хүртэлх/ иргэнийг “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулна.

Ховд аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичиж алдаршуулсан дурсгалын гэрчилгээг дурсгалын зүйлийн хамт гардуулна.

3.2. Аймгийн ИТХ-н дарга дараах шагналыг олгоно.

3.2.1. Аймгийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөл

Тухайн салбарт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, үр бүтээлтэй ажиллаж буй иргэнийг шалгаруулж аймгийн ИТХ-ын Хүндэт өргөмжлөл, мөнгөн шагнал 30000 төгрөгөөр шагнана. Нэг хүнд 5 жилийн дотор давхардуулан олгохгүй.

3.3. Аймгийн Засаг дарга дараах шагналыг олгоно.

3.3.1. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Ховдын төлөө” медаль:

Улсад 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан, аймаг, улс, тив, дэлхийд нэрээ дуурсгасан Монгол улсын иргэнийг, мөн аймаг, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан гадаадын зочид төлөөлөгчдийг Засаг даргын нэрэмжит “Ховдын төлөө” медалиар шагнаж, медалийн үнэмлэх олгоно.

3.3.2. Аймгийн Засаг даргын Жуух бичиг:

Тухайн салбарт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, үр бүтээлтэй ажиллаж буй иргэнийг шалгаруулж аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнана.

Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан ажилтныг аймгийн Засаг даргын захирамжаар 1 сарын үндсэн цалингийн 20 хувиар шагнах шийдвэр гаргах ба шагналын санг шагналд тодорхойлсон байгууллага хариуцна. Нэг хүнд 5 жилийн дотор давхардуулан олгохгүй.

3.3.3. Аймгийн Хүндэт өргөмжлөл:

Тухайн салбарт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж үр бүтээлтэй ажиллан амжилтанд хүрсэн иргэнийг шалгаруулж Хүндэт өргөмжлөл, мөнгөн шагнал 30000 төгрөгөөр шагнана. Нэг хүнд 5 жилийн дотор давхардуулан олгохгүй.

3.3.4. Аймгийн есөн алдартан:

Тухайн жилд ажил хөдөлмөр, мэргэжлийн ур чадвараараа онцгой амжилт гарган, аймаг, сумын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан дараах салбарын есөн алдартанг шалгаруулж, аваргын энгэрийн тэмдэг, тууз, батламж, 100000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаана. Үүнд:

- 1.Боловсролын салбарын алдартан
- 2.Эрүүл мэндийн салбарын алдартан
- 3.Барилга, дэд бүтцийн салбарын алдартан
- 4.Санхүүгийн салбарын алдартан
- 5.Бизнесийн салбарын алдартан
- 6.Байгаль орчин, хүнс хөдөө, аж ахуйн салбарын алдартан
- 7.Соёл урлагийн салбарын алдартан
- 8.Төрийн захиргаа, хууль зүйн салбарын алдартан
- 9.Спортын салбарын алдартан

3.3.5. Аймгийн тэргүүний сум, баг, байгууллага:

Аймгийн сум, албан байгууллагын тухайн жилийн ажлын амжилт, үйл ажиллагааны чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн байр эзлүүлж 3 хүртэл сум, 3 хүртэл баг, 3 хүртэл байгууллагыг тус бүр шалгаруулж, Хүндэт өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаана.

Сум: тэргүүн байр 3,0 сая төгрөг, дэд байр 2,0 сая төгрөг, гутгаар байр 1,0 сая төгрөг, баг: тэргүүн байр 1,5 сая төгрөг, дэд байр 1,0 сая төгрөг, гутгаар байр 0,5 сая төгрөг, байгууллага: тэргүүн байр 1,5 сая төгрөг, дэд байр 1,0 сая төгрөг, гутгаар байр 0.5 сая төгрөгөөр тус тус шагнаж, шалгарсан сум, баг, байгууллагын дарга нарыг тэргүүн байр 1 сарын үндсэн цалин, дэд байр үндсэн цалингийн 75 хувь, гутгаар байр үндсэн цалингийн 50 хувиар тус бүр шагнаж урамшуулна.

3.3.6. Аймгийн түүх, дурсгалыг бэлэгдсэн буюу аймгийн сүлд, лого бүхий дурсгалын зүйлийг зочид төлөөлөгчдөд олгож болно.

3.4. Аймгийн шагналын бүртгэл, мэдээллийн санг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн болон Засаг даргын Тамгын газрын аймгийн шагнал хариуцсан мэргэжилтэн нар тус тус хариуцан, он цагийн бүртгэл хөтлөнө.

Дөрөв. Шагналын сан, шагналыг дагалдах мөнгөн шагнал:

4.1. Аймгийн шагналын санг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

4.1.1. ИТХ-ын дарга, Засаг даргын нөөц хөрөнгийн шагнал, урамшуулалд зориулсан төсөв

4.1.2. Төсвийн урамшуулал

4.1.3. Бусад эх үүсвэр.

Тав. Шагналыг гардуулах, мэдээлэх, алдаршуулах:

5.1. Энэ журамд заасан шагналуудыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчид, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар ёслол хүндэтгэлтэй гардуулна.

5.2. Аймгийн шагналаар шагнагдагсдыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилна.

...oOo...

ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ

/загвар/

- 1.Овог.
- 2.Нэр.
- 3.Хүйс:
- 4.Боловсрол, мэргэжил:
- 5.Одоо эрхэлж байгаа албан тушаал
- 6.Байгууллагын нэр
- 7.Урьд болон одоо ажиллаж байгаа газар: /Ажилд анх орсноосоо эхлэн оны дарааллаар нь бичнэ/

Зураг 4x6

Д/д	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1	Жишээ:	1990-2005	
2		2005-2010	Оны дарааллаар дээрээс нь доошоо бичнэ

8.Улсад ажилласан нийт жил, үүнээс тухайн салбарт болон хамт олны дотор ажилласан жил

Улсад ажилласан жил	Тухайн салбарт ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил

9.Урьд нь шагнагдаж байсан шагналууд: /Төрийн дээд шагнал, салбарын болон аймгийн бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан: оны дарааллаар/

Д/д	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		

10.Шагнуулах үндэслэл: / Ажил байдлын тодорхойлолтын хэсгээс ажлын гол үзүүлэлт, ажлын ололт амжилтын үндэслэлийг 3-5 өгүүлбэрт багтаан бичнэ./

11.Ямар шагналаар шагнуулах: / Шагнуулахаар тодорхойлж байгаа шагналын нэрийг бичнэ. /

12.Хамт олны санал: